

## АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2021 оны 07 дугаар сарын 27

Сонгон шалгаруулалт шалгаруулалтын нэр: **Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших MV-004487 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Зүүн үнэгт” талбайд (1, 3, 5, 6, 9-р хүдрийн биет) уулын ажил гүйцэтгэж бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах**

**Монголросцветмет ТӨҮГ нь** эрх бүхий оролцогчдоос бүтээгдэхүүн хуваах зарчмаар хамтран ажиллах ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн санал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **50000** төгрөгөөр худалдан авна.

Оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **сүүлийн 2 жил буюу 2019 он, 2020 он.**

Жил тус бүрийн борлуулалтын орлого нь **500 сая төгрөгөөс багагүй байх.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **500 сая төгрөгөөс багагүй байх ба харилцагч банкнаас тодорхойлолт авах тохиолдолд уг сонгон шалгаруулалт ялсан тохиолдолд зээл олгох боломжтой байна гэсэн утга бүхий Захиалагчид гаргасан банкны тодорхойлолтыг шаардлага хангасан материал гэж үзнэ.**

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **сүүлийн 2 жил буюу 2019 он, 2020 он**

Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих хугацаа: **сүүлийн 2 жил буюу 2019 он, 2020 он**

Ижил төстэй ажил гэдэгт уул уурхайн ашиглалт, хүдэр олборлолтын чиглэлээр ажиллаж байсан гэж ойлгох бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэж байсан туршлага бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсхүл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **тийм, ААН-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Уул уурхайн чиглэлээр олборлолтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий тэмдэглэлтэй байх**

Саналыг 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан сонгон шалгаруулалтыг 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 10 цаг 20 минутад нээнэ.

Гадаадын хуулийн этгээд санал ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: Эрхтэй  
Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцохгүй

Сонирхсон этгээд сонгон шалгаруулалтын баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот 51, ш/х – 002  
Баянзүрх дүүрэг, Энх тайвны өргөн чөлөө. 22-р хороо,  
“Монголросцветмет” ТӨҮГ-ийн байр, 504 тоот өрөө,  
И-мейл: [mailbox@monros.mn](mailto:mailbox@monros.mn).  
Утас/факс: 976-11-458380(ф), 976-11-450060-158,